



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/301

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 44 дүгээр зөвлөмжийн дагуу улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих Сургуулийн барилга, 240 суудал (Өвөрхангай, Нарийнтээл сум) ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер (БСШУСЯ/201902047)-ийг 1468268555 (нэг тэрбум дөрвөн зуун жаран найман сая хоёр зуун жаран найман мянга таван зуун тавин тав) төгрөгөөр Тэд констракшн ХХК -иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3. Шалгарсан гүйцэтгэгч аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100635